



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

20 11 оны 07 сарын 18 өдөр

Дугаар A/39

Талын шанд

Г Газар ашиглуулах тухай Г

Монгол Улсын Газрын тухай хуулийн 31.2, 30.2 31.1, 31.3, 32.1, 32.5, 33.1,33.2 дахь заалууд, сумын ИТХ-ын 7/04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гоби Коуль Энд Энержи ХХК-ийн 483,05 га газрыг 25 жилийн хугацаатай ашиглуулсугай.
2. Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж жил бүр гэрээгээ дүгнүүлж ажиллахыг газар эзэмшигч аж ахуй нэгжид хариуцуулсугай.
3. Эзэмшүүлсэн газарт хяналт тавин ажиллахыг Газрын даамал /Б.Додгон/, Байгаль орчны хяналтын улсын байцаагч /Б.Балдан/ нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2007 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 27 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б. РАДНААСЭД

My doc /Zairamj

07000299

ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2011 оны 07 сарын 20 ний өдөр

Говь-Алтай аймгийн Чандмань сум

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Говь-Алтай аймгийн Чандмань сумын Засаг даргын 2011 оны 07-р сарын 18-ний өдрийн А/139 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж Чандмань сумын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Бадамсүрэн овогтой Доржсүрэн, газар эзэмшигчийг төлөөлж "Гоби Коул энд Энержи" ХХК-ийн Ерөнхий захирал Д.Уранбилэг нар энэхүү гэрээг байгуулав.

Дараах бичиг баримт нь энэхүү гэрээний хавсралт буюу салшгүй хэсэг байна. Үүнд:

1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг;
2. Газар эзэмшүүлэгчээс газар эзэмшигчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт;
3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ 483.53 га. Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт

1. Уурхайн зориулалтаар

Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ
483.53 га ✓

2.2. Газрын төлбөрийн хэмжээ

Хөрс хуулалт хийгдсэн 75.03 га талбайн нэгжийн төлбөр 16,000 төгрөг /арван зургаан мянган төгрөг/

Үлдсэн 408.5 га талбайн нэгжийн төлбөр 8,000 төгрөг /найман мянган төгрөг/

Бүгд төлбөр жилд 4,468,480 төгрөг /дөрвөн сая дөрвөн зуун жаран найман мянга дөрвөн зуун наян төгрөг/ байна. Үүнээс:

1-р улиралд 1,117,120 төгрөг ✓

3-р улиралд 1,117,120 төгрөг ✓

2-р улиралд 1,117,120 төгрөг ✓

4-р улиралд 1,117,120 төгрөг ✓

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар ашиглуулагчийн сумын Төрийн сангийн _____ банкны _____ тоот дансанд шилжүүлж байна.

2.4. Газар эзэмшүүлэх тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тооцно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна.

Гурав. Газар эзэмшигчийн эрх, үүрэг ✓

- 3.1. Гэрээний нөхцөлийн дагуу газрыг эзэмших, ашиглах;
- 3.2. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр гэрчилгээний хугацааг сунгуулах;

3.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх;

3.6. Төлбөрийг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хоног тутам алданги төлөх;

3.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;

3.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил, ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;

3.9. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

Дөрөв. Газар эзэмшүүлэгчийн эрх, үүрэг

4.1. Газар эзэмшигч газрыг гэрээний дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;

4.2. Уг газрыг холбогдох хууль тогтоомж, энэхүү гэрээний дагуу эзэмшүүлэх;

4.3. Газрыг гэрээний нөхцлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу "Газрын тухай" хуулийн 40.1.1.- 40.1.6. дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

4.4. Газар эзэмших гэрээг жил бүр дүгнэх;

4.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

5.1. Газар эзэмших эрх болон гэрээний хугацаа дуусгавар болоход тухайн газар дээрх барилга байгууламж, бусад эд хөрөнгийг хэрхэх тухай анх эрх олгосон шийдвэрт заасан бол тэр дагуу, харин заагаагүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.2. Энэхүү гэрээгээр эзэмших эзэмшил газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь хууль тогтоомжид тусгасан байдлаас илүүгүй байна.

5.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

Зургаа. Бусад зүйл

6.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, гэрээ хүчин төгөлдөр болж мөрдөгдсөн өдрөөс эхлэн **хорин таван (25)** жилийн хугацаатай байгуулав.

6.3. Талууд энэхүү гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн жил бүр гэрээний биелэлтийн талаар дүгнэж байхаар харилцан тохиролцов.

6.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар эзэмшүүлэгч: Говь-Алтай аймгийн Чандмань сум, Засаг даргын Тамгын газрын байр

Газар эзэмшигч: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Тээвэрчдийн гудамж, Нарны зам 18, Жигүүр гранд оффис центр, 8-р давхарт 801 тоот

Утас: 330828
Факс: 330829

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар эзэмшүүлэгчийг төлөөлж:
Говь-Алтай аймгийн Чандмань сумын
Газрын асуудал эрхэлсэн албан
тушаалтан Бадарц овогтой

Бадарц
[Signature]
/гарын үсэг/ [Signature]
/тамга/



Газар эзэмшигчийг төлөөлж:
Гоби Коул энд Энержи ХХК-ийн
Ерөнхий захирал Д.Уранбилэг

[Signature]
[Signature]
/гарын үсэг/ [Signature]
/тамга/



Энэхүү гэрээний нэг хувийг _____ тоот дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.

МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 0201430

Тобч - Коул энд өмөржи
Х.Х.К

(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

Товч - Арчаг аймаг (нийслэл)-ийн Чандмань сум (дүүрэг)-ын

нутаг дэвсгэрт Засаг даргын 2011 оны 07 сарын 18 өдрийн А/39 тоот

шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын _____ дугаар бүхий


25, га м²/га/ газрыг 25 жилийн хугацаатай

Товч А. А. Чандмань сум Зөвмөг -д
(газрын байршлын хаяг, нэр)

Зөвмөг сум зориулалтаар

эзэмшүүлэхээр энэхүү гэрчилгээг олгов.

Товч - Арчаг аймаг (нийслэл)-ийн Чандмань сум (дүүрэг)-ын



ГАЗРЫН АЛБАНЫ ДАРГА / СУМЫН ГАЗРЫН ДААМАЛ

[Signature] Б. Доргов
(гарын үсэг) (нэр)

2011 оны 07 сарын 20 өдөр

МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 0201431

Төбч. Кооп. Энд зөв тусч
Х.Х.К

(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

Төбч. Аймаг (нийслэл)-ийн Чандмань сум (дүүрэг)-ын

нутаг дэвсгэрт Засаг даргын 2011 оны 07 сарын 18 өдрийн А/39 тоот
шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын _____ дугаар бүхий

256,56 м²/га/ газрыг 25 жилийн хугацаатай

Т.А.А. Чандмань сум Зөв тусч

(газрын байршлын хаяг, нэр)

Замчигчин

зориулалтаар

эзэмшүүлэхээр энэхүү гэрчилгээг олгов.

Төбч. Аймаг (нийслэл)-ийн Чандмань сум (дүүрэг)-ын

ГАЗРЫН АЛБАНЫ ДАРГА / СУМЫН ГАЗРЫН ДААМАЛ



[Signature]

(гарын үсэг)

Б.Эгдэл

(нэр)

2011 оны 07 сарын 20 өдөр

МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 0201429

Товч Кохь өнд төр тч
Х.Х.К

(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

Товч Аймаг аймаг (нийслэл)-ийн Чандмань сум (дүүрэг)-ын

нутаг дэвсгэрт Засаг даргын 2011 оны 07 сарын 18 өдрийн А/39 тоот

шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын _____ дугаар бүхий


201,77 м² /га/ газрыг 25 жилийн хугацаатай

Т.А.А. Чандмань сум Зөвлөг -д
(газрын байршил хаяг, нэр)

Замчилуу зориулалтаар

эзэмшүүлэхээр энэхүү гэрчилгээг олгов.

Товч Аймаг аймаг (нийслэл)-ийн Чандмань сум (дүүрэг)-ын



ГАЗРЫН АЛБАНЫ ДАРГА / СУМЫН ГАЗРЫН ДААМАЛ

Б. Доргоо (нэр)
(гарын үсэг)

2011 оны 07 сарын 20 өдөр